

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 3 дугаар
сарын 24-ны өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

Г “Туул сонгино усны нөөц” ХК-ийн 7
үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, 9.5, Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, “Туул сонгино усны нөөц” ХК-ийн 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын 03 дугаар тогтоолын 2, 4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. Тус компанийн хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлаас “Туул сонгино усны нөөц цогцолбор” төсөл хэрэгжих боломжгүй гэж үзэж уг төслийн хэрэгжилтийг зогсоох тухай шийдвэр гаргасан байх тул “Туул сонгино усны нөөц” ХК-ийн үнэт цаасны арилжааг зогсоосугай.

2. Тус компанийн хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлаас “Туул сонгино усны нөөц цогцолбор” төсөл хэрэгжих боломжгүй болсон гэж үзэж, уг төслийн хэрэгжилтийг зогсоох тухай шийдвэр гаргасан тухай олон нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд ажлын 5 хоногийн дотор мэдээлэхийг “Туул сонгино усны нөөц” ХК /Гүйцэтгэх захирал Марат Утегенов/-д үүрэг болгосугай.

3. Төслийн хэрэгжилтийг зогсоох, төслийн хэрэгжилтийг бусдад шилжүүлэх тухай хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүрт өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн тухай 2010 оны 4 дүгээр сард багтаан бичгээр мэдэгдэж, эрхийг нь хэрэгжүүлэх арга хэмжээг зохих ёсоор шуурхай зохион байгуулж, тайлагнахыг “Туул сонгино усны нөөц” ХК /Гүйцэтгэх захирал Марат Утегенов/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын 2, 3 дахь заалтын хэрэгжилтийг бүрэн хангах хүртэл тус Хорооны 2010 оны 252 дугаар тогтоолын 2 дахь заалтын дагуу тусгаарласан хөрөнгийг компанид олгохгүй байхаар тогтсугай.

5. Төслийн хэрэгжилт зогссон тул тус компанийн хувьцааг үнэт цаасны зах зээлд цаашид арилжих боломжгүй гэж үзсүгэй.

6. Энэхүү тогтоолын 5 дахь заалттай холбогдуулан компанийг татан буулгах эсэх, эсхүл өөрчлөн байгуулах асуудлыг хувь нийлүүлэгчдийн дараагийн хурлаараа хэлэлцүүлж, шийдвэр гаргуулахыг “Туул сонгино усны нөөц” ХК /Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Алишер Джуманов/, /Гүйцэтгэх захирал Марат Утегенов/-д үүрэг болгосугай.

7. Хувь нийлүүлэгчдийн хурлаас компанийг өөрчилж, үнэт цаасны бүртгэлд шинээр бүртгүүлэх тохиолдолд зохих журмын дагуу холбогдох баримт материалыг бүрдүүлж, хүсэлтээ 2010 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор багтаан гаргахыг “Туул сонгино усны нөөц” ХК /Гүйцэтгэх захирал Марат Утегенов/-д мэдэгдсүгэй.

8. Энэхүү тогтоолын 6-д заасан хугацаанд үнэт цаасыг шинээр бүргүүлэх хүсэлтийг Хороонд гаргаагүй тохиолдолд “Туул сонгино усны нөөц” ХК-ийн үнэт цаасыг холбогдох бүртгэлээс хасахыг “Туул сонгино усны нөөц” ХК /Гүйцэтгэх захирал Марат Утегенов/-д анхааруулсугай.

9. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлж ажиллахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН